

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/297/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦОГТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70272248 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Өлзийт экаунт аудит" ХХК

Гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэжав

Утас: 70130460 Цахим хаяг: auditulziit@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НД	Нийгмийн Даатгал
ТӨҮГ	Төрийн Өмчийн Үйлдвэрийн Газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэл осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/135
танай _____ -ны № _____ -т

**ТӨВ АЙМГИЙН БАЯНЦОГТ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Х.ДОРЖ ТАНАА**

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 49,835.9 мянган төгрөгийн зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул дараах асуудлуудыг хязгаарлалттай дүгнэлтийн үндэс гэж үзлээ. Үүнд:

- Тайлант хугацаанд 49,835.9 мянган төгрөгийн бараа материалыг тоолж баталгаажуулаагүй.
- Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бэлтгэж ирүүлээгүй.
- Тус байгууллагын нягтлан бодогч нь санхүүгийн тайлангаа төсвийн тухай хуулийн цагалбарт хугацаанд бэлтгээгүй,

019020263

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 6 сарын 21-ны өдрийн 241 тоот тогтоолоор “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох” албан хаагчдын цалингийн хэмжээнд өөрчлөлт орсон байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	57,430,067.18	135,330,791.08
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	14,747,596.93	85,494,939.83
312	Банканд байгаа бэлэн мөнгө	14,747,596.93	85,494,939.83
3121	Төгрөг	14,747,596.93	85,494,939.83
31211	Төрийн сангийн харилцах	14,747,596.93	85,494,939.83
35	БАРАА МАТЕРИАЛ	42,682,470.25	49,835,851.25
351	Түүхий эд материал	11,990,392.80	11,990,392.80
35110	Тусгай зориулалттай материал	11,990,392.80	11,990,392.80
354	Хангамжийн материал	30,692,077.45	37,845,458.45
35410	Бичиг хэргийн материал	718,400.00	1,810,950.00
35420	Аж ахуйн материал	24,322,666.45	25,390,241.45
35440	Түлш, шатах тослох материал	00.00	395,000.00
35460	Хүнсний материал	5,651,011.00	10,249,267.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,081,139,992.01	2,030,516,741.77
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,081,139,992.01	2,030,516,741.77
392	Биет хөрөнгө	2,029,042,475.34	1,978,419,225.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,032,249,266.00	2,032,249,266.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(241,381,353.61)	(280,475,278.93)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	173,307,321.50	174,206,321.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(44,178,793.78)	(62,849,743.30)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	100,508,006.91	113,643,506.91
39208	Хуримтлагдсан элэгдэл	(36,133,093.84)	(42,725,969.24)
39209	Зам, гүүрний байгууламж	6,000,000.00	6,000,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(1,200,000.00)	(1,500,000.00)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	20,800,000.00	20,800,000.00
39217	Ном	19,071,122.16	19,071,122.16
393	Биет бус хөрөнгө	52,097,516.67	52,097,516.67
39301	Программ хангамж	89,000.00	89,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,483.33)	(1,483.33)
39303	Бусад биет бус хөрөнгө	52,010,000.00	52,010,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,138,570,059.19	2,165,847,532.85
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,138,570,059.19	2,165,847,532.85
51	Засгийн газрын хувь оролцоо	2,138,570,059.19	2,165,847,532.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	449,177,766.52	449,177,766.52
51101	Өмч: - төрийн	449,177,766.52	449,177,766.52
512	Хуримтлагдсан үр дүн	937,604,167.95	964,881,641.61
51210	Өмнөх үеийн үр дүн	937,604,167.95	937,604,167.95
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	27,277,473.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	751,788,124.72	751,788,124.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,138,570,059.19	2,165,847,532.85

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,284,871,127.70	1,059,690,948.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	358,103,127.70	13,566,648.00
120	Нийтлэг татварын бус орлого	358,103,127.70	13,566,648.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	150,648.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	150,648.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	252,987,800.00	1,046,124,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	827,409,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	827,409,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	673,780,200.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,992,600.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,992,600.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	211,995,200.00	218,714,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	211,995,200.00	218,714,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	992,709,846.92	1,032,413,309.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	992,709,846.92	1,032,413,309.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	915,035,444.44	996,311,452.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	506,399,163.62	567,186,162.24
210101	Үндсэн цалин	361,112,523.35	401,440,179.43
210102	Нэмэгдэл	115,216,194.39	137,033,596.20
210104	Урамшуулал	30,070,445.88	28,712,386.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,298,724.47	71,401,047.86
210201	Тэтгэврийн даатгал	44,052,744.65	48,649,950.67
210202	Тэтгэмжийн даатгал	5,063,698.10	5,697,590.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,050,958.40	4,558,294.30
210204	Ажилгүйдлийн даатгал	1,003,927.36	1,140,078.64
210205	Эрүүл мэндийн даатгал	10,127,395.96	11,355,133.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	182,814,753.50	217,677,043.26
210301	Гэрэл, цахилгаан	10,782,190.00	13,998,163.26
210302	Түлш, халаалт	171,750,063.50	203,448,880.00
210303	Цэвэр, бохир ус	282,500.00	230,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,377,230.20	00.00
210401	Бичиг хэрэг	403,300.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	4,045,875.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,938,475.00	00.00
210408	Бараа материал ақталсны зардал	989,580.20	00.00
2105	Нормативт зардал	31,108,240.00	20,620,280.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	288,500.00	00.00
210502	Хоол, хүнс	28,632,840.00	20,620,280.00

Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,186,900.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,003,200.00	990,000.00
210604	Урсгал засвар	1,003,200.00	990,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,231,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	1,231,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	630,000.00	3,643,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	630,000.00	3,643,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	118,173,132.65	114,793,319.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,010,325.00	44,015,714.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,975,075.00	6,120,020.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	107,187,732.65	64,657,585.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,674,402.48	36,101,856.74
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,075,897.48	47,556.74
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	2,075,897.48	47,556.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	75,598,505.00	36,054,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,164,605.00	27,394,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,563,900.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	19,428,700.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,441,300.00	8,659,800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	292,161,280.78	27,277,638.66
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,187,340.61	165.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,187,340.61	165.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(5,187,340.61)	(165.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	286,973,940.17	27,277,473.66

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	548,664,600.00	1,046,274,948.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	150,648.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	150,648.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	150,648.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	150,648.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	548,664,600.00	1,046,124,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	827,409,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	827,409,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	374,820,800.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,992,600.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,992,600.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	132,851,200.00	218,714,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	132,851,200.00	218,714,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	495,914,971.95	965,477,605.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	495,914,971.95	965,477,605.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	442,552,541.95	929,375,748.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	287,290,441.54	567,186,162.24
210101	Үндсэн цалин	210,542,500.20	401,440,179.43
210102	Нэмэгдэл	58,912,746.85	137,033,596.20
210104	Урамшуулал	17,835,194.49	28,712,386.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,915,396.41	71,401,047.86
210201	Тэтгэврийн даатгал	21,141,573.40	48,649,950.67
210202	Тэтгэмжийн даатгал	2,438,455.78	5,697,590.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,950,764.60	4,558,294.30
210204	Ажилгүйдлийн даатгал	487,691.08	1,140,078.64
210205	Эрүүл мэндийн даатгал	4,896,911.55	11,355,133.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	102,803,649.00	217,677,043.26
210301	Гэрэл, цахилгаан	6,067,363.00	13,998,163.26
210302	Түлш, халаалт	96,648,786.00	203,448,880.00
210303	Цэвэр, бохир ус	87,500.00	230,000.00
2105	Нормативт зардал	15,040,730.00	36,164,100.00
210502	Хоол, хүнс	15,040,730.00	36,164,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	990,000.00
210604	Урсгал засвар	00.00	990,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	182,000.00	3,643,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	182,000.00	3,643,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,320,325.00	32,313,795.00

Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,801,100.00	26,193,775.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,519,225.00	6,120,020.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,362,430.00	36,101,856.74
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	47,556.74
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	00.00	47,556.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,362,430.00	36,054,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,369,830.00	27,394,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,563,900.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	19,428,700.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	8,659,800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	52,749,628.05	80,797,342.90
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	10,050,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	10,050,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	10,050,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	10,050,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	(10,050,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	52,749,628.05	70,747,342.90
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	14,747,596.93
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	52,749,628.05	85,494,939.83

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	449,177,766.52	754,017,124.48	648,401,228.02	00.00	1,851,596,119.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	449,177,766.52	754,017,124.48	648,401,228.02	00.00	1,851,596,119.02
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(183,340.59)	00.00	(183,340.59)
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	449,177,766.52	751,788,124.72	937,604,167.95	00.00	2,138,570,059.19
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	449,177,766.52	751,788,124.72	937,604,167.95	00.00	2,138,570,059.19
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	449,177,766.52	751,788,124.72	937,604,167.95	00.00	2,138,570,059.19
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	27,277,473.66	00.00	27,277,473.66
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	449,177,766.52	751,788,124.72	964,881,641.61	00.00	2,165,847,532.85

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		14,747,596.93	(14,747,596.93)	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	844,156,800.00	756,813,005.10	87,343,794.90	89.65%
УРСГАЛ ЗАРДАЛ	844,156,800.00	756,813,005.10	87,343,794.90	89.65%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	801,967,100.00	720,758,705.10	81,208,394.90	89.87%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	636,082,400.00	567,186,162.24	68,896,237.76	89.17%
Үндсэн цалин	434,523,200.00	401,440,179.43	33,083,020.57	92.39%
Нэмэгдэл	170,639,900.00	137,033,596.20	33,606,303.80	80.31%
Урамшуулал	30,919,300.00	28,712,386.61	2,206,913.39	92.86%
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	79,510,700.00	71,401,047.86	8,109,652.14	89.80%
Тэтгэврийн даатгал	54,067,200.00	48,649,950.67	5,417,249.33	89.98%
Тэтгэмжийн даатгал	6,360,900.00	5,697,590.37	663,309.63	89.57%
ҮОМШӨ-ний даатгал	5,088,700.00	4,558,294.30	530,405.70	89.58%
Ажилгүйдлийн даатгал	1,272,200.00	1,140,078.64	132,121.36	89.61%
Эрүүл мэндийн даатгал	12,721,700.00	11,355,133.88	1,366,566.12	89.26%
Норматив зардал	36,343,600.00	36,164,100.00	179,500.00	99.51%
Хоол, хүнс	36,343,600.00	36,164,100.00	179,500.00	99.51%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	6,289,700.00	3,643,600.00	2,646,100.00	57.93%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	924,400.00		924,400.00	0.0%
Мэдээллийн технологийн зардал	5,365,300.00	3,643,600.00	1,721,700.00	67.91%
Бараа үйлчилгээний бусад зардал	43,740,700.00	42,363,795.00	1,376,905.00	96.85%
Бараа үйлчилгээний бусад зардал	37,079,300.00	36,243,775.00	835,525.00	97.75%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,661,400.00	6,120,020.00	541,380.00	91.87%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,189,700.00	36,054,300.00	6,135,400.00	85.46%
Бусад урсгал шилжүүлэг	42,189,700.00	36,054,300.00	6,135,400.00	85.46%
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж	33,529,900.00	27,394,500.00	6,135,400.00	81.70%
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	8,659,800.00	8,659,800.00		100.00%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	828,334,100.00	827,560,348.00	773,752.00	99.91%
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	827,409,700.00	827,409,700.00	0.00	100.00%
Улсын төсвөөс санхүүжих	827,409,700.00	827,409,700.00	0.00	100.00%
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	924,400.00	150,648.00	773,752.00	16.30%
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	924,400.00	150,648.00	773,752.00	16.30%

Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		14,747,596.93	(14,747,596.93)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		85,494,939.83	(85,494,939.83)	
АЖИЛЛАГСДЫН ТОО	37.00	35.00	2.00	94.59%
Удирдах ажилтан	1.00	1.00		100.00%
Гүйцэтгэх ажилтан	23.00	21.00	2.00	91.30%
Үйлчлэх ажилтан	13.00	13.00		100.00%

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	222,414,600.00	218,714,600.00	3,700,000.00	98.34%
УРСГАЛ ЗАРДАЛ	222,414,600.00	218,714,600.00	3,700,000.00	98.34%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	222,414,600.00	218,667,043.26	3,747,556.74	98.32%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	221,414,600.00	217,677,043.26	3,737,556.74	98.31%
Гэрэл, цахилгаан	17,675,600.00	13,998,163.26	3,677,436.74	79.19%
Түлш, халаалт	203,449,000.00	203,448,880.00	120.00	100.00%
Цэвэр, бохир ус	290,000.00	230,000.00	60,000.00	79.31%
Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	990,000.00	10,000.00	99.00%
Урсгал засвар	1,000,000.00	990,000.00	10,000.00	99.00%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	47,556.74	(47,556.74)	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	222,414,600.00	218,714,600.00	3,700,000.00	98.34%
Орон нутгийн төсвөөс санхүүжих	222,414,600.00	218,714,600.00	3,700,000.00	98.34%
Орон нутгийн төсвөөс	222,414,600.00	218,714,600.00	3,700,000.00	98.34%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
АЖИЛЛАГСДЫН ТОО	37.00	35.00	2.00	94.59%
Удирдах ажилтан	1.00	1.00		100.00%
Гүйцэтгэх ажилтан	23.00	21.00	2.00	91.30%
Үйлчлэх ажилтан	13.00	13.00		100.00%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургууль нь эрхэм зорилгоо “Хүүхдийн нийгэм, сэтгэл зүй, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, боловсрол эзэмшихэд тулгарч буй бэрхшээлийг арилгаж сурах тэгш боломж бүрдүүлэх, хувь хүний онцлогт нийцүүлэн сургалт, үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулах, хамтран суралцах арга барилыг сургалтад нэвтрүүлэх” гэж тодорхойлсон. Тус байгууллага ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхлэн явуулж байна

Төв аймгийн Баянцогт сумын ерөнхий боловсролын сургууль нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилт, хэрэгжүүлэх 12 арга хэмжээтэй баталснаас нийт 93,5 %-тай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Баянцогт сумын ерөнхий боловсролын сургууль нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас хяналт, шалгалтын ажил хийгдээгүй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянцогт сумын ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянцогт сумын ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 27,277.4 мянган төгрөгөөр буюу 1,3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	14,747.6	85,494.9	70,747.3
Бараа материал	42,682.5	49,835.9	7,153.4
Үндсэн хөрөнгө	2,081,140.0	2,030,516.7	(50,623.3)
Нийт хөрөнгө	2,138,570.10	2,165,847.5	27,277.40
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,138,570.10	2,165,847.50	27,277.40
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,138,570.10	2,165,847.50	(27,277.40)

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 70,747.3 мянган төгрөгөөр өссөн нь төсөв гүйцэтгэлээр санхүүждэгтэй холбоотой.

Бараа материал дансанд 19,630.2 мянган төгрөгийн бараа материалыг мөнгөөр худалдан авч, 24,036.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, бараа материалын үлдэгдэл 49,835.9 мянган төгрөг байна.

Үндсэн хөрөнгө данс тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 13,416.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг худалдан авч, 13,416.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан нь үндсэн хөрөнгөөр нэмэгдэж байгуулсан элэгдлээр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,165,847.5 мянган төгрөг болж 27,277.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 611,940.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 222,414.6 мянган төгрөг, нийт 834,354.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Баянцогт сумын ерөнхий боловсролын сургууль нь дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 230,497.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2023 оны урсгал зардлын төсвийг 1,056,152.0 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 1,056,152.0 мянган төгрөгөөс 1 удаа тодотгол хийж 1,046,274.9 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх

1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,046,274.9 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, зарцуулаагүй 6,719.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 975,480.1 мянган төгрөг буюу 89,7 хувьтай байна.

Хүснэгт 2.

					/мянган төгрөг/
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1.1	80266-Байр ашиглалтын үйлчилгээ	1,776.4	1,776.4		100%
1.2	80312-Сургалт, семинар	888.2	888.2		100%
1.3	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,776.4	1,776.4		100%
1.4	81801-Үдийн цай хөтөлбөр	33,529.9	27,394.5	6,135.4	81,7%
1.5	81806-Дотуур байрны үйлчилгээ	61,630.5	56,404.7	5,225.8	91.5%
1.6	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	18,601.6	18,601.6		100%
1.7	81823-Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	3,996.8	3,996.8		100%
1.9	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	585,306.7	535,548.2	49,758.5	91.4%
1.10	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	134,809.4	110,954.6	23,854.8	
1.11	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	150.7	150.7		100%
1.12	81848-Сурах бичгийн түрээс	962.5	962.5		100%
1.13	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	211,995.2	218,714.6	6,719.4	100%
	Дүн	1,055,424.30	977,169.20	78,255.10	89,6%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Баянцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 301,097.8 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн. Үүнд: Үдийн цай болон дотуур байрны хүүхдийн хоол хүнс 469,097.2 мянган төгрөгөөр нээлттэй тендер шалгаруулахаар, 91,333.1 мянган төгрөгийн бичиг хэрэг, хичээл үйлдвэрлэл, томилолт, тээвэр шатахуун, төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, мэдээлэл технологийн зардлуудыг шууд худалдан авалтаар, 921,959.1 мянган төгрөгийн тогтмол зардал, 86,872.0 мянган төгрөгийн бараа үйлчилгээний бусад зардлаас шууд гэрээ байгуулахаар тус бүр төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 1,764,636.4 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн. Худалдан авалтын дүн өссөн нь түлш халаалтын үнэ нэмэгдсэн, сурагчдын тоо нэмэгдсэнтэй холбоотой байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ний аудитор Ч.Эрдэнэжав гүйцэтгэж, чанарын хяналтыг Чанарын хяналтын менежер Ц.Бямбажав хэрэгжүүлж, дараагийн хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2024 оны 02 дүгээр сарын 23 -ны өдрийн 24 дугаар албан бичгээр ирүүлсэн боловч залруулагдаж баталгаажуулсан тайланг 3 дугаар сарын 11 өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Баянцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Баянцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зарлага 992,709.8 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 14,890.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 11,167.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв аймгийн Баянцогт сумын ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан байр ашиглалттай холбоотой зардлыг 3,737.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 2,646.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,376.9 мянган төгрөг нийт 7,760.5 мянган төгрөгийг хэмнэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд Төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих 171 мэдээллээс 149 мэдээллийн хугацаандаа, 4 мэдээллийг хугацаа хоцроож, 18 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлсэн бол, 2 албан шаардлага өгөгдсөнийг хэрэгжүүлэн 50 хувь хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Зөвлөмжийн биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 09-ны өдрийн 24 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	43,743.7	1	43,743.7	50%
Зөвлөмж	1	2,056.1	1	2,056.1	100%
Нийт дүн	3	45,799.8	2	45,799.8	100%

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн боловч, хөрөнгө бараа материалын тооллогын үр дүнг хэлэлцэн баталгаажуулаагүй албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн дараагийн аудитаар анхан шатны баримт хөтлөлт, ерөнхий журнал, гүйлгээ баланс, тайлангуудын хоорондын уялдаа холбоо, нягтлан бодох бүртгэлд тавих хяналтыг анхаарч үзэх нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 167,172.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 167,172.8 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

Залруулсан алдаа:

- Мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлын дүн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн дүнгээс 43,401.3 мянган төгрөгийн зөрүүтэй нь УСНББОУС 1-Санхүүгийн Тайлангийн Толилуулга-Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг" гэсэн стандарт, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

- Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн, өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн дүн 123,771.5 мянган төгрөгийн зөрүүтэй нь УСНББОУС 1-Санхүүгийн Тайлангийн Толилуулга-Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг" гэсэн стандарт, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 49,835.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 49,835.9 мянган төгрөгийн албан шаардлага, 1 сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

5.1 Албан шаардлага

Жилийн эцэст 49,835.9 мянган төгрөгийн "Бараа материал"-ыг тоолж баталгаажуулаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана, 70.2.1-д "Үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор", 70.2.2-т "Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/" гэж заасантай нийцэхгүй, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн суутган тооцоогүй татварыг холбогдох этгээдээр төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага

Тус байгууллагын нягтлан бодогч нь санхүүгийн тайлангаа төсвийн тухай хуулийн цагалбарт хугацаанд бэлтгээгүй, аудитад шаардлагатай нотлох баримтуудыг бүрэн ирүүлж ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” г гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-д “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага” э хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хандив тусламжийн орлогын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд эцэг, эхчүүд болон иргэд, төгсөгчдөөс авсан хандив тусламжаар үндсэн хөрөнгө, бараа материалыг авахдаа “Сургууль цэцэрлэг хөгжүүлэх сан”-ийн үлгэрчилсэн дүрмийг хэрэгжүүлж ажиллаагүй байгаа нь УСНББОУС-9 стандартын 17-д “Тухайн орлогыг хүлээн авсан бараа, үйлчилгээний бодит үнэ цэнээр хэмжих ба шилжүүлсэн аливаа мөнгө буюу мөнгөтэй адилтгах хөрөнгийн дүнгээр тохируулна. Хүлээн авсан бараа, үйлчилгээний бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадахгүй тохиолдолд орлогыг тухайн өгсөн бараа, үйлчилгээний бодит үнэ цэнээр орлогыг хэмжих ба шилжүүлсэн аливаа мөнгө буюу мөнгөтэй адилтгах хөрөнгийн дүнгээр тохируулна.”, Боловсролын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 Боловсролын санхүүжилт нь улс, орон нутгийн төсөв, сургалтын төлбөр, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагаас дүрэмд заасан үйл ажиллагаанд зориулсан хандив, тусламж, зээл, боловсролын байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого зэрэг нийтлэг эх үүсвэрээс бүрдэнэ; Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2008 оны 56/64 дугаар тушаалын 1.1 Өмчийн хэлбэр харгалзахгүй их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургууль /цаашид сургууль гэх/, цэцэрлэгт дотоод, гадаадын хуулийн этгээд, иргэн, эцэг эх, асран хамгаалагч, сайн дурын байгууллагаас /цаашид хандивлагч болон тусламж үзүүлэгч гэх/ санаачлан сайн дурын үндсэн дээр тухайн байгууллагын дүрэмд заасан үйл ажиллагаанд зориулан өгсөн хандив, буцалтгүй тусламжийн орлогыг “Сургууль, цэцэрлэг хөгжүүлэх сан”-д бүртгэж авах, зарцуулах, хяналт тавих, мэдээ тайланд тусгах харилцааг энэхүү дүрмээр зохицуулна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Буцалтгүй тусламжийн орлогыг холбогдох дүрэм журамд заасны дагуу бүртгэж тайлагнаж хэвших

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайлан	1	43,401.3					1	43,401.3				
Санхүү байдлын тайлан	1	123,771.5					1	123,771.5				
Дүн	2	167,172.8					2	167,172.8				

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бараа материал тоолж баталгаажуулаагүй	1	49,835.9			1	49,835.9						
Хандив тусламжийн орлогыг бүртгэхдээ сан байгуулж ажиллаагүй	1	-					1	-				

Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хуулийн хугацаанд санхүүгийн тайлан бэлтгэж баталгаажуулаагүй	1	-					1		1	-		
Дүн	3	49,835.9			1	49,835.9	1	-	1	-		



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар

92-17225502-ТӨА-2024/297/НА-СТА-ТШЗ

Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 49,835,851.25 төгрөгийн бараа материалыг тоолж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана, 70.2.1-д "Үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор", 70.2.2-т "Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/" гэж заасныг, Санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.2-д "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тооллогыг иж бүрэн хийж, тооллогын бүртгэлийг нэгтгэн илтгэх хуудас, үр дүнг тооцон ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Х.Дорж, нягтлан бодогч Б.Угтахбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ЭРДЭНЭЖАВ



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 101-17225502-ТӨА-2024/296/НА-СТА-ТШЗ

Зуунмод

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын нягтлан бодогч нь санхүүгийн тайлангаа төсвийн тухай хуулийн цагалбарт хугацаанд бэлтгээгүй, аудитад шаардлагатай нотлох баримтуудыг бүрэн ирүүлж ажиллаагүй байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-д "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Зөрчил гаргасан нягтлан бодогч Б.Угтахбаярт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Х.Дорж, нягтлан бодогч Б.Угтахбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ЭРДЭНЭЖАВ

